



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/120

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.13, 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.8, 32.1.9 32.1.10, Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилтын байдал хүндэрсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 62 дугаар тогтоол”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.1, аймгийн Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаваржилт хүндэрсэнтэй холбоотойгоор аймгийн аюулгүй нөөцөд өвс, худалдан авах зардалд шаардагдах 47,211,000 (дөчин долоон сая хоёр зуун арван нэгэн мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Хууль журмын дагуу гэрээ байгуулан ажиллаж, холбогдох зардал 25,960,500 (хорин таван сая есөн зуун жаран мянга таван зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс, 21,250,500 (хорин нэгэн сая хоёр зуун тавин мянга таван зуу) төгрөгийг хандив тусламжаас тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч, Шуурхай штабын дарга (Б.Наранбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4213400298